



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2024/170/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Булган аймаг
2024 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580
Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2580 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид
Утас: 9511-2689 Цахим хаяг: tseb.audit@gmail.com

Ахлах аудитор Ш.Ганчимэг Утас: 99377360
Цахим хаяг: shagdarganchimeg44@jmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 262

танай _____ ны № _____ т

ГУРВАНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.НАРАНТУНГАЛАГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Гурванбулаг сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванбулаг сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам”-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 179,435.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

БШУС-ын 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/230 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар хуваарилсан 38,636.2 мянган төгрөгийн нөхөн хангалтын санхүүжилтээс 28,616.0 мянган төгрөгөөр аж ахуйн нэгж байгуулга, хувь хүнтэй гэрээ байгуулан компьютер, сургалтын болон бусад тоног төхөөрөмж худалдан авсан байна.

006020576

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөөнд 6 зорилтын 24 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 92.4 хувиар тайлагнасан байна. Тайлант онд сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээгээр IV түвшинд, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр нийт 36 багшаас 31 багш I-IV түшинд тус тус үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>128,276,116.12</u>	<u>314,771,452.61</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,427,992.75	179,435,559.24
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	11,427,992.75	179,435,559.24
3121	Төгрөг	11,427,992.75	179,435,559.24
31211	Төрийн сангийн харилцах	11,427,992.75	179,435,559.24
35	БАРАА МАТЕРИАЛ	116,848,123.37	135,335,893.37
351	Түүхий эд материал	66,292,549.37	66,114,899.37
35110	Тусгай зориулалттай материал	65,954,899.37	65,954,899.37
35130	Эм боох материал	337,650.00	160,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	7,691,730.00	7,723,680.00
354	Хангамжийн материал	38,768,844.00	53,272,314.00
35410	Бичиг хэргийн материал	-	3,377,800.00
35420	Аж ахуйн материал	24,797,203.00	36,156,093.00
35460	Хүнсний материал	10,404,729.00	10,171,509.00
35470	Бусад хангамжийн материал	3,566,912.00	3,566,912.00
35600	Мал амьтад	4,095,000.00	8,225,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,902,184,368.21</u>	<u>2,923,482,409.40</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,902,184,368.21	2,923,482,409.40
391	Газар		
392	Биет хөрөнгө	2,843,380,743.21	2,864,931,909.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,830,170,299.82	3,830,170,299.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,228,318,006.49)	(1,272,179,287.34)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	237,068,628.77	310,070,407.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	(98,814,170.32)	(122,470,719.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	91,359,504.17	116,287,504.17
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,921,448.14)	(42,030,930.92)
39217	Ном	44,835,935.40	45,084,635.40
393	Биет бус хөрөнгө	58,803,625.00	58,550,500.00
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(84,375.00)	(337,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	57,538,000.00	57,538,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,030,460,484.33</u>	<u>3,238,253,862.01</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,317,600.00</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,317,600.00	-
413	Өглөг	2,317,600.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,143,600.00	-
4136	Бусад өглөг	174,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	174,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,028,142,884.33</u>	<u>3,238,253,862.01</u>

51	Засгийн газрын хувь оролцоо	3,028,142,884.33	3,238,253,862.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,204,609,946.28	1,204,609,946.28
51101	Өмч: - төрийн	1,204,609,946.28	1,204,609,946.28
512	Хуримтлагдсан үр дүн	1,179,302,309.56	1,389,413,287.24
51210	Өмнөх үеийн үр дүн	1,179,302,309.56	1,179,302,309.56
51220	Тайлант үеийн үр дүн	-	210,110,977.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	644,230,628.49	644,230,628.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,030,460,484.33	3,238,253,862.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,472,008,600.00	1,955,091,970.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	73,282,470.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	73,282,470.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	73,282,470.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	73,282,470.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,472,008,600.00	1,881,809,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,212,128,100.00	1,645,649,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,212,128,100.00	1,645,649,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	259,880,500.00	236,160,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	259,880,500.00	236,160,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,427,442,059.20	1,749,110,992.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,427,442,059.20	1,749,110,992.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,362,172,634.20	1,668,408,412.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	904,699,000.23	1,124,971,619.00
210101	Үндсэн цалин	662,640,617.28	790,715,018.00
210102	Нэмэгдэл	174,609,405.89	275,580,653.00
210104	Урамшуулал	67,448,977.06	58,675,948.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,591,706.02	142,195,719.51
210201	Тэтгэврийн даатгал	85,719,389.03	97,299,165.98
210202	Тэтгэмжийн даатгал	10,326,348.69	11,452,001.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,311,491.94	9,054,370.28
210204	Ажилгүйдлийн даатгал	3,158,602.92	2,220,695.66
210205	Эрүүл мэндийн даатгал	23,075,873.44	22,169,485.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	220,003,886.00	224,892,520.37
210301	Гэрэл, цахилгаан	7,843,886.00	12,732,520.37
210302	Түлш, халаалт	212,160,000.00	212,160,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	204,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	204,000.00
2105	Нормативт зардал	37,424,270.00	46,152,045.00
210502	Хоол, хүнс	37,424,270.00	46,152,045.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,923,000.00	2,203,100.00
210604	Урсгал засвар	1,923,000.00	2,203,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,678,500.00	11,715,411.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,683,500.00	4,954,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,995,000.00	6,761,011.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,852,271.95	116,073,997.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,281,820.00	29,002,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,950,025.00	10,191,210.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,620,426.95	76,880,437.81
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,269,425.00	80,702,579.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	65,269,310.00	75,378,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	65,269,310.00	63,442,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	11,935,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	115.00	5,324,179.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	115.00	5,324,179.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	44,566,540.80	205,980,977.68
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	8,485,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	8,485,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,283,358.47	4,355,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,283,358.47	4,355,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,283,358.47)	4,130,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	43,283,182.33	210,110,977.68

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,472,252,600.00	1,881,809,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	244,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	244,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	244,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	244,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,472,008,600.00	1,881,809,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,212,128,100.00	1,645,649,200.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,212,128,100.00	1,645,649,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	259,880,500.00	236,160,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	259,880,500.00	236,160,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,414,144,607.25	1,688,905,924.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,414,144,607.25	1,688,905,924.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,355,668,802.25	1,608,171,394.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	928,081,067.27	1,126,104,092.18
210101	Үндсэн цалин	689,224,237.73	785,001,162.18
210102	Нэмэгдэл	200,396,932.89	279,042,729.00
210104	Урамшуулал	38,459,896.65	62,060,201.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,209,638.98	141,063,246.33
210201	Тэтгэврийн даатгал	79,042,527.88	96,421,107.79
210202	Тэтгэмжийн даатгал	9,296,802.78	11,266,535.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,437,382.19	8,956,327.83
210204	Ажилгүйдлийн даатгал	1,859,420.57	2,282,422.38
210205	Эрүүл мэндийн даатгал	18,573,505.56	22,136,853.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	217,860,286.00	227,036,120.37
210301	Гэрэл, цахилгаан	7,843,886.00	12,143,012.59
210302	Түлш, халаалт	210,016,400.00	214,893,107.78
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/		
2105	Нормативт зардал	46,688,680.00	45,918,825.00
210502	Хоол, хүнс	46,688,680.00	45,918,825.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	3,800,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	3,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,331,700.00	11,073,611.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,683,500.00	4,954,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,648,200.00	6,119,211.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,997,430.00	53,175,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,521,300.00	39,428,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,476,130.00	13,746,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,475,805.00	80,734,529.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,475,690.00	75,410,350.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,475,690.00	63,474,750.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	11,935,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	115.00	5,324,179.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	115.00	5,324,179.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	58,107,992.75	192,903,575.49

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	50,331,100.00	24,896,009.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,331,100.00	24,896,009.00
2200	Дотоод эх үүсвэрээр	50,331,100.00	24,896,009.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	50,331,100.00	24,896,009.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(50,331,100.00)	(24,896,009.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	7,776,892.75	168,007,566.49
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		11,427,992.75
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,427,992.75	179,435,559.24

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,204,609,946.28	644,230,628.49	1,179,302,309.56	3,028,142,884.33
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	210,110,977.68	210,110,977.68
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,204,609,946.28	644,230,628.49	1,389,413,287.24	3,238,253,862.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,895,083,600.00	1,683,581,744.88	211,501,855.12	88.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,895,083,600.00	1,683,581,744.88	211,501,855.12	88.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,811,859,300.00	1,608,171,394.88	203,687,905.12	88.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,262,343,000.00	1,126,104,092.18	136,238,907.82	89.21
210101	Үндсэн цалин	854,974,800.00	785,001,162.18	69,973,637.82	91.82
210102	Нэмэгдэл	341,147,000.00	279,042,729.00	62,104,271.00	81.80
210104	Урамшуулал	66,221,200.00	62,060,201.00	4,160,999.00	93.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157,792,700.00	141,063,246.33	16,729,453.67	89.40
210201	Тэтгэврийн даатгал	107,299,100.00	96,421,107.79	10,877,992.21	89.86
210202	Тэтгэмжийн даатгал	12,623,400.00	11,266,535.07	1,356,864.93	89.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,098,700.00	8,956,327.83	1,142,372.17	88.69
210204	Ажилгүйдлийн даатгал	2,524,700.00	2,282,422.38	242,277.62	90.40
210205	Эрүүл мэндийн даатгал	25,246,800.00	22,136,853.26	3,109,946.74	87.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	232,360,300.00	227,036,120.37	5,324,179.63	97.71
210301	Гэрэл, цахилгаан	13,000,000.00	12,143,012.59	856,987.41	93.41
210302	Түлш, халаалт	219,160,300.00	214,893,107.78	4,267,192.22	98.05
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	-	200,000.00	0.00
2105	Нормативт зардал	51,439,900.00	45,918,825.00	5,521,075.00	89.27
210502	Хоол, хүнс	51,439,900.00	45,918,825.00	5,521,075.00	89.27
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,800,000.00	3,800,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	3,800,000.00	3,800,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,982,400.00	11,073,611.00	4,908,789.00	69.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,801,100.00	4,954,400.00	1,846,700.00	72.85
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,181,300.00	6,119,211.00	3,062,089.00	66.65
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,141,000.00	53,175,500.00	34,965,500.00	60.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,369,100.00	39,428,600.00	34,940,500.00	53.02
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,771,900.00	13,746,900.00	25,000.00	99.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,224,300.00	75,410,350.00	7,813,950.00	90.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	83,224,300.00	75,410,350.00	7,813,950.00	90.61
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	71,288,700.00	63,474,750.00	7,813,950.00	89.04
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,935,600.00	11,935,600.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,881,809,500.00	(1,881,809,500.00)	
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	1,645,649,200.00	(1,645,649,200.00)	
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	1,645,649,200.00	(1,645,649,200.00)	

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	236,160,300.00	(236,160,300.00)	
132001	Орон нутгийн төсвөөс	-	236,160,300.00	(236,160,300.00)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		11,427,992.75	(11,427,992.75)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		179,435,559.24	(179,435,559.24)	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад 3,806.7 мянган төгрөгийн алдааг залруулж, нийт 13,094.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,663.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 9,431.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

3. Төлбөрийн акт

1. Дотуур байрны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах мах, махан бүтээгдэхүүний норм, хэмжээг нэмэгдүүлж, 3,663.0 мянган илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “норматив батлах тухай” А/166, А/559, 222 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-г тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.5-т “Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих хоёр мэдээллийг хугацаа хоцроож, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-д “Дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор, 6.1.1-д “Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг, жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор” шилэн дансны цахим системд байршуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Багш ажилтнуудад 9,431.7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгохдоо тухайн багшийн манлайлал, мэргэжлийн ур чадварыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнээгүй байна.

Өгсөн зөвлөмж: БШУС, ХНХС, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9-р тушаалыг хэрэгжүүлж, ажиллах.

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			Тоо	Дүн
							Тоо	Дүн	Дүн	Тоо	Дүн		
Харилцах дансны үлдэгдэл буурч, бараа материал дансны үлдэгдэл нэмэгдсэн.	1	3,806.7			1	3,806.7	1	3,806.7					
Дүн	1	3,806.7	-	-	1	3,806.7	-	3,806.7	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дотуур байрны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах мах, махан бүтээгдэхүүний норм, хэмжээг нэмэгдүүлж, тооцож, зарлага гаргасан.	1	3,663.0	1	3,663.0					-	-	-	-
Ур чадварын нэмэгдлийг сургуулийн багш ажилтнуудад олгохдоо тухайн багшийн манлайлал, мэргэжлийн ур чадварыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнээгүй.	1	9,431.7					1	9,431.7				
Дүн	2	13,094.7	3	3,663.0			1	9,431.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

